



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2019 оны 10 сарын 01 өдөр

Дугаар А/341

Мандалговь

Монгол хурандаа нийгэмлэгтэй  
хамтран ажиллах тухай

Монгол Улсын "Батлан хамгаалах тухай хууль"-ийн 17 дугаар зүйлийн 1-ийн 10 дахь хэсэг, Монгол Улсын Ерөнхийлөгчийн "Үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр", "Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-үүдэд дэвшүүлсэн эх орноо хайрлан хамгаалах, эх орноороо бахархах, эх оронч үзэл, хүмүүжлийг түгээн дэлгэрүүлэх, төлөвшүүлэх, ахмад үеийнхний эх оронч, баатарлаг, хөдөлмөрч замнал, гавьяа зүтгэлийг алдаршуулан сурталчлах, хүүхэд, залуучуудад тайлбарлан таниулах зорилтыг хэрэгжүүлэх, Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалаар баталсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.3 дахь заалт, аймгийн Засаг даргын 2019 оны 10 дугаар сарын 1-ний өдрийн 13 дугаар хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн Ажлын алба, Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын чиглэл, шийдвэрийн дагуу улс орон даяар зохион байгуулагдаж буй "Монгол хурандаа" нийгэмлэгийн Тэргүүн, Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн шинжээч, доктор, профессор хурандаа Ч.Баатар болон Үндэсний аюулгүй байдлыг хангах чиг үүрэг бүхий байгууллагуудын төлөөлөл бүхий хурандаа нарын "Сурталчилгаа, ухуулгын баг"-аас Монгол улсын Төр, Засгийн бодлого шийдвэр, тэдгээрээс авч хэрэгжүүлж буй арга хэмжээг сурталчлах, түүний хэрэгжилтийн талаар ард иргэдийн санал бодлыг нь сонсож, судалгаа хийн, дүгнэлт боловсруулах, эх орноороо бахархах, эх оронч үзэл, хүмүүжлийг түгээн дэлгэрүүлэх, төлөвшүүлэх, талаар авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, төр, засгийн удирдлагыг бодит мэдээллээр хангах зорилгоор Дундговь аймагт 9 дүгээр сарын 16-наас 17-ны өдрүүдэд ажиллахад хоол, байраар хангах, хурал лекцэд Үндэсний аюулгүй байдлыг хангах чиг үүрэг бүхий байгууллагуудын албан хаагчид, Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн сурагч, оюутнуудыг хамруулахыг Цэргийн штабын дарга (дэд хурандаа Ш.Гансүх)-д даалгасугай.

Хоёр. Тус арга хэмжээнд шаардагдах 2.194.100 (хоёр сая нэг зуун ерэн дөрвөн мянга нэг зуу) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ц.Эрдэнэсүрэн) нягтлан бодогч (Д.Нандинцэцэг)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



О.БАТ-ЭРДЭНЭ

488190973

Аймгийн Засаг даргын 2019 оны 10 дугаар сарын  
01-ний өдрийн 134 дугаар захирамжийн хавсралт

МОНГОЛ ХУРАНДАА НИЙГЭМЛЭГТ ЗАРЦУУЛСАН ЗАРДАЛ

Д/д	Зарцуулагдах хөрөнгө	Үнэ (төгрөгөөр)	Тоо	Нийт үнэ (төгрөгөөр)
1	Royal буудал	520000	1	520000
2	Хоол өдөр Гурилтай шөл	7000	22	154000
3	Хоол өдөр үхрийн жигнэсэн мах	8900	22	195800
4	Цай	500	22	11000
5	Орой тахианы мах салат	5000	32	160000
6	Банштай шөл	7000	32	224000
7	Бөөрөнхий мах шпагетти	9500	32	304000
8	Ус	1000	37	37000
9	Ундаа	3000	37	111000
10	Цай	500	32	16000
11	Жимс	20000	5	100000
12	Айраг	3490	62 л	216000
13	Ааруул	20160	5 кг	100800
14	Чихэр	44500	1	44500
	Нийт			2.194.100 төгрөг